МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайвны өргөн чөлөө 16, Засгийн газрын IX байр,
Утас/Факс: (976-51) 26 23 50, И-мэйл: info@pcsp.gov.mn,
Вэбсайт: www.pcsp.gov.mn

2026.01.09 № А-1/57

танай ____________-ны №____________-т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗАРТ

Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх 2025 оны жилийн эцсийн тайлан, түүнд хийсэн дүн шинжилгээний тайланг хүргүүлж байна.

Хавсралт 7 хуудастай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

Боловсруулсан:
Хянасан:
132001487
Хүргэх:

A-5/2026

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТЭД ДОТООД ХЯНАЛТ ХИЙСЭН ТАНИЛЦУУЛГА**

*(2025 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар)*

2026-01-09 Улаанбаатар хот

***Дотоод хяналтын зорилго***

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хууль, Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2025 оны А/66 тушаалаар батлагдсан "Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэх журам" болон холбогдох бусад хууль, эрх зүйн актуудын хүрээнд шийдвэрлэж байгаа эсэхэд хяналт тавих, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хэрэгжилт хариуцлагыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.

***Дотоод хяналт хийсэн дүгнэлт***

2025 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, албан тушаалтанд хандаж, иргэд, аж ахуй нэгж, албан хаагчдаас нийт 135 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлж, 124 өргөдөл гомдлыг шийдвэрлэж, хугацаа хэтэрсэн 6, хяналтад 4 өргөдөл гомдол, 1 өргөдөлд хариу өгөх шаардлагагүй тайлбар мэдээлэл ирүүлсэн ба шийдвэрлэлт 92.5 хувьтай байна.

Тайлант хугацаанд шийдвэрлэсэн 124 өргөдөл гомдлын 35 нь хуулийн хугацаанд шийдвэрлэгдээгүй хугацаа хоцорч шийдвэрлэгдсэн, 6 нь шийдвэрлэгдээгүй хугацаа хэтэрсэн үр дүнтэй байна.

***Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах "11 11"*** төвөөс Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрыг хяналтад авч шийдвэрлэхийг үүрэг болгосон 17 иргэний өргөдөл гомдлыг судлан холбогдох арга хэмжээг авсан байна.

Шийдвэрлэсэн байдлыг авч үзвэл: "Эрдэнэс Монгол" ХХК – 5, "Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ – 1, "Авто замын засвар арчлалтын нэгтгэл" ТӨХК – 4, "Засгийн газрын автобааз" УТҮГ – 1 нийт 11 өргөдөл, гомдлыг харьяаллын дагуу холбогдох байгууллагуудад шилжүүлж, 6 өргөдөл, гомдол, хүсэлтийг судалж холбогдох арга хэмжээг авч хариу хүргүүлсэн. *(Хүснэгт – 1)*

***Ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг хэлтсээр нь авч үзвэл:***

- Захиргаа, удирдлагын хэлтэс 25 шийдвэрлэсэн 24 үүнээс хугацаандаа шийдвэрлэж хариу өгсөн 19, хугацаа хоцорч шийдвэрлэсэн 5, хяналтад байгаа 1, шийдвэрлэлт 96.0 хувь;
- Хууль, эрх зүйн хэлтэс 13 шийдвэрлэсэн 12 үүнээс хугацаандаа шийдвэрлэж хариу өгсөн 10, хугацаа хоцорч шийдвэрлэсэн 2, шийдвэрлэлт 100 хувь;
- Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс 65 шийдвэрлэсэн 60 үүнээс хугацаандаа шийдвэрлэж хариу өгсөн 42, хугацаа хоцорч шийдвэрлэсэн 18, шийдвэрлэгдээгүй хугацаа хэтэрсэн 4, хяналтад байгаа 1, шийдвэрлэлт 92.3 хувь;
- Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс 30 шийдвэрлэсэн 27 үүнээс хугацаандаа шийдвэрлэж хариу өгсөн 18, хугацаа хоцорч шийдвэрлэсэн 9, шийдвэрлэгдээгүй хугацаа хэтэрсэн 2, *хяналтад байгаа 1,* шийдвэрлэлт 90.0 хувь;
- Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс 2 шийдвэрлэсэн 1 үүнээс хугацаа хоцорч шийдвэрлэсэн 1, хяналтад байгаа 1 шийдвэрлэлт 50 хувьтай байна. *(Хүснэгт – 2)*

*Хүснэгт – 1*

| д/д | 11 11-төвөөс | Хариуцсан албан хаагч | Шийдвэрлэсэн байдал | | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| | | | Холбогдох арга хэмжээг авсан | Харьяаллын дагуу шилжүүлсэн байгууллага | |
| 1 | Иргэн Б.Сугармаа 2024.12.26 | Г.Дэлгэрмаа | Судалж хариу хүргүүлсэн. 2025.01.13 | - | Утсаар 88264896 |
| 2 | Иргэн П.Юмчин 2025.01.20 | Г.Дэлгэрмаа | - | "АЗЗАН" ТӨХК-нд 2025.01.30 | Албан бичгээр А-1/204 |
| 3 | Иргэн У.Мөнхөө 2025.02.12 | Ц.Шинэхүү | - | "Эрдэнэс критикал минералс" ТӨҮГ 2025.03.20 | Албан бичгээр А-1/574 |
| 4 | Иргэн Н.Алтанцэцэг 2025.02.11 | Д.Дариймаа | - | "Эрдэнэс Монгол" ХХК | Албан бичгээр А-1/435 |
| 5 | Иргэн Л.Энхбаатар 2025.02.14 | Д.Дариймаа | - | "Эрдэнэс Монгол" ХХК 2025.02.27 | Бусад байдлаар |
| 6 | Ш.Оюунтунгалаг 2025.02.19 | Г.Дэлгэрмаа | - | "АЗЗАН" ТӨХК-нд 2025.03.10 | Албан бичгээр А-1/459 |
| 7 | Иргэн Б.Лхагваа 2025.02.26 | Б.Амарбаясгалан | - | "Засгийн газрын автобааз" УТҮГ 2025.03.10 | Албан бичгээр А-1/477 |
| 8 | Иргэн Д.Алтанчимэг 2025.05.27 | Н.Дагиймаа | Гомдол гаргагчтай уулзаж асуудлыг шийдвэрлэсэн | - | Амаар 2025.06.10 |
| 9 | Иргэн Г.Шануубал 2025.08.05 | Г.Дэлгэрмаа | - | "АЗЗАН" ТӨХК-нд 2025.08.14 | Албан бичгээр А-1/1569 |
| 10 | Иргэн Д.Бурмаа 2025.08.08 | Г.Дэлгэрмаа | - | "АЗЗАН" ТӨХК-нд 2025.08.14 | Албан бичгээр А-1/1569 |
| 11 | Иргэн П.Одгэрэл 2025.09.09 | Г.Туул | Хүсэлтийг хүлээн авч уулзах цаг боломжтой талаар мэдэгдсэн | - | Утсаар 99056487 |
| 12 | Иргэн Л.Одгэрэл 2025.10.15 | Д.Дариймаа | Гомдлын дагуу "Зам, тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ-аас тайлбар авахад листний мөнгө олгогдсон байв. | - | Гомдол гаргагчийн гэрийн хаяг байхгүй, холбогдох утас нь холбогдоогүй. |
| 13 | Иргэн П.Октябрь 2025.11.04 | Б.Билгүтэ | - | "Эрдэнэс Монгол" ХХК 2025.12.02 | Албан бичгээр А-1/2274 |
| 14 | Иргэн Х.Алтанхуяг 2025.11.10 | Б.Билгүтэ | - | "Эрдэнэс Монгол" ХХК 2025.12.02 | Албан бичгээр А-1/2300 |
| 15 | Иргэн Х.Туяамаа 2025.11.27 | Н.Дагиймаа | Гомдол гаргагчтай уулзаж шийдвэрлэсэн | - | Амаар 2025.12.12 |
| 16 | Иргэн О.Мөнх-Эрдэнэ 2025.12.03 | Б.Билгүтэ | - | "Эрдэнэс Монгол" ХХК 2025.12.12 | Албан бичгээр А-2/2447 |
| 17 | Иргэн Г.Бадамсүрэн 2025.12.10 | Д.Дариймаа | Гомдол гаргасан иргэнд и-мэйлээр хариу хүргүүлсэн. 2025.12.23 | | И-мэйл хаягаар |

*Хүснэгт – 2*

| Салбар хэлтэс | Бүгд | Шийдвэрлэлтийн байдал | | | | Хариу өгөх шаардлагагүй | Шийдвэрлэлт -ийн хувь/хугацаа хоцорч шийдвэрлэсэн хувь | Байгууллагад ээлэх хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Шийдвэрлэсэн | Хяналтад байгаа | Хугацаа хоцорч шийдвэрлэсэн | Шийдвэрлэгдээгүй хугацаа хэтэрсэн | | | |
| Захиргаа удирдлагын хэлтэс | 25 | 24 | 1 | 5 | - | - | 96.0/20.8 | 18.5 |
| Хууль эрх зүйн хэлтэс | 13 | 12 | - | 2 | - | 1 | 100/16.6 | 9.6 |
| Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс | 65 | 60 | 1 | 18 | 4 | - | 92.3/30.0 | 48.2 |
| Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс | 2 | 1 | 1 | 1 | - | - | 50/50 | 1.5 |
| Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс | 30 | 27 | 1 | 9 | 2 | - | 90.0/33.3 | 22.2 |
| **Нийт** | **135** | **124** | **4** | **35** | **6** | **1** | **92.5/28.2** | **100.0** |

***Ирүүлсэн өргөдөл, гомдлыг хэлбэрээр нь авч үзвэл:***

- Бичгээр 130;
- Утсаар 5.

***Ирүүлсэн өргөдөл, гомдлыг төрлөөр нь авч үзвэл:***

- Өргөдөл 53 (39.3%);
- Гомдол 47 (34.8%);
- Хүсэлт 31 (22.9%);
- Санал 2 (1.5%);
- Мэдээлэл 2 (1.5%).

***Агуулгаар нь авч үзвэл:***

- Байгууллагын албан хаагчдаас ирүүлсэн чөлөө хүссэн, ажилд орох, ажлаас чөлөөлөгдөх, орон сууцны тухай 22 (16.3%);
- Орон сууц хувьчлалтай холбоотой болон орон сууцны эрхийн бичиг авах, нэр шилжүүлэх тухай 25 (18.5);
- Төрийн өмчит хуулийн этгээдтэй холбоотой 36 (26.7%);
- Түрээс, эд хөрөнгөтэй холбоотой 27 (20.0%);
- Бусад 25 (18.5).

***Өргөдөл, гомдлыг илгээгчээр нь авч үзвэл:***

- Иргэнээс 89 (65.9%);
- Албан хаагчдаас 22 (16.2%);
- Байгууллагаас 24 (18.0%).

***Шийдвэрлэж хариу өгснийг хэлбэрээр нь авч үзвэл: (34)***

- Албан бичгээр 72;
- Утсаар 6;

- Бусад байдлаар 45;
- Амаар 1.

Хугацаа хоцорч шийдвэрлэсэн өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийхэд:

- Захиргаа, удирдлагын хэлтсийн 5 өргөдөл, гомдлын 2 нь хуулийн хугацаанаас өмнө шийдвэрлэсэн, 1 нь өргөдөл гомдлын хугацааг хэлтсийн даргад уламжлан 1 удаа сунгалт хийж хуулийн хугацаанд шийдвэрлэсэн боловч цахим системд 6-84 хоног хугацаа хоцорч хаасан, 1 өргөдөл гомдлыг шийдвэрлэх талаар холбогдох байгууллагаас тодруулах, нэмэлт мэдээлэл авч хариу өгсөн тул 6 хоногоор тус тус хоцорч шийдвэрлэсэн;
- Хууль эрх зүйн хэлтсийн 2 өргөдөл, гомдлыг 4-18 хоног хугацаа хоцорч шийдвэрлэсэн ба 1 өргөдөл гомдлыг 16 хоногоор хугацаа хоцорч шийдвэрлэж, цахим системд шийдвэрлэснээс хойш 2 хоногийн дараа хаасан нь хугацаа хэтрэлт 18 хоногоор тайланд тусгагдсан, 1 нь өөр хэлтэст хуваарилагдаж, чиг үүргийн дагуу шилжүүлэн авч шийдвэрлэхэд 4 хоногийн хугацаа хоцорсон;
- Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн 18 өргөдөл гомдлын 7 нь орон сууц эзэмшилтэй холбоотой бусад байгууллагуудаас нэмэлт тодруулга, лавлагаа шаардсан тул цаг хугацаа шаардсан тул хуулийн хугацаанд шийдвэрлэгдээгүй (1-115 хоног), 5 нь төрийн өмчит хуулийн этгээдийн албан тушаалтны хөдөлмөрийн харилцаатай холбоотой (20-100 хоног) үүнээс 4 нь хугацаандаа шийдвэрлэгдсэн ч цахим системд хаагаагүйгээс хугацаа хоцорсон төлөвтэй, 1 нь Засгийн газрын тогтоолоор чиг үүрэг өөр байгууллагад шилжсэн тул харьяаллын дагуу "Эрдэнэс критикал минералс үйлдвэр" ТӨҮГазарт шилжүүлсэн, 1 нь Хууль эрх зүйн хэлтэст цохогдсон боловч хэлтсийн мэргэжилтнүүд тохиролцож, чиг үүргийн хүрээнд шилжүүлж 68 хоногоор хоцорч шийдвэрлэсэн;
- Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн 9 өргөдөл, гомдол түрээсийн сонгон шалгаруулалттай холбоотой асуудлаар хандсан тул хуулийн хугацаанд шийдвэрлэх боломжгүй нэмэлт тодруулга шаардлагатай 1-56 хоногоор хоцорч шийдвэрлэсэн;
- Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтсийн 1 өргөдөл, гомдлыг судалж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар хариуцан шийдвэрлэх боломжгүй тул чиг үүргийн дагуу эрчим хүчний яаманд шилжүүлсэн байна.

Шийдвэрлэгдээгүй хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдолд дүн шинжилгээ хийхэд:

- Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс хариуцан шийдвэрлэх 4 үүний 2 нь орон сууц хувьчлалтай холбоотой, 1 нь төрийн өмчит хуулийн этгээдийн удирдлагын урамшуулалтай холбоотой, 1 нь өмч хувьчлалтай холбоотой асуудлаар холбогдох байгууллагуудаас лавлагаа, мэдээлэл, нэмэлт тодруулга авах шаардлагатай тул хуулийн хугацаанд шийдвэрлэгдээгүй судлагдаж байгаа үр дүнтэй;
- Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс хариуцан шийдвэрлэх 2 өргөдөл, гомдол үүний 1 нь төрийн өмчийн хөрөнгө бүртгэлтэй холбоотой, 1 нь Оросын Холбооны Улсын өмчлөлийн 60 айлын орон сууц хувьчлалтай холбоотой асуудлаар хандсан тул мөн холбогдох байгууллагуудаас нэмэлт тайлбар, тодруулга авах, судлах шаардлагатай цаг хугацаа шаардсан учраас хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэх боломжгүй тус тус хүлээгдэж байгаа үр дүнтэй байна.

**Цаашид авах арга хэмжээний санал /ЗӨВЛӨМЖ/**

- Шийдвэрлэгдээгүй хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдлыг нэн даруй шийдвэрлэх;
- Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцын тэмдэглэлийг цахим системд товч тодорхой тэмдэглэл хөтөлж хэвших;
- Албан хаагчид хариуцан шийдвэрлэсэн өргөдөл, гомдлыг Able Cloud цахим системд хугацаанд нь хариуцлагатайгаар хааж хэвших;
- Бичиг, хэргийн ажилтан сар бүрийн өргөдөл, гомдлын мэдээг байгууллагын өргөдөл, гомдол хариуцсан албан хаагчид өгч, өргөдөл, гомдол хариуцсан албан хаагч Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.2.8-д заасны дагуу өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээг байгууллагын албан ёсны цахим хуудаст улирал тутам нээлттэй, ил тод, байршуулж байх;
- Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх боломжгүй тохиолдолд шийдвэрлэх хуулийн хугацааг холбогдох хэлтсийн даргад танилцуулж, зөвшөөрөл авснаар өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэж, хугацааг 30 хүртэлх хоногоор сунгах бөгөөд явцын тэмдэглэлийг цахим системд товч тодорхой хөтөлж байх.

Танилцсан:
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Б.ЦЭНГЭЛ

Хянасан:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Н.ГАНБОЛД

Боловсруулсан:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН МЭРГЭЖИЛТЭН Д.ЦЭРЭНЛХАМ

## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2026.01.09

Улаанбаатар хот

| Байгууллагын нэр | МД | Өргөдөл | | | Гомдол | Дүн | Хүлээн авсан хэлбэр | | | | | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Хүсэлт | Санал | Мэдэгдэл | | | Биечлэн | Утсаар | Цахим аар | 11-11 төвөөс шилжүүл сэн | Албан бичгээр | |
| А | Б | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар | 1 | 62 | 2 | 2 | 47 | 113 | - | 5 | - | 17 | 91 | 113 |
| **Нийт дүн** | | **62** | **2** | **2** | **47** | **113** | **-** | **5** | **-** | **17** | **91** | **113** |

Тайлбар: Өргөдөл, гомдлын тайлан мэдээнд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдаас ирүүлсэн 22 өргөдлийг хасаж тооцсон болно.

Мэдээ гаргасан: Хүний нөөцийн мэргэжилтэн Н.Дагиймаа ............................

/Албан тушаал/ /Нэр/ /Гарын үсэг/

2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр

## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2026.01.09 Улаанбаатар хот

| Байгууллагын нэр | МД | Өргөдлийн тоо | Өргөдөл (хүсэлт, санал, мэдэгдэл) | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Шийдвэрлэсэн | | | | | Шийдвэрлэгдээгүй | | | |
| | | | Хугацаагаар | | Шийдвэрлэлтийн байдал | | | Бусад байгууллагад шилжүүлсэн | | | |
| | | | Хуулийн хугацаанд шийдвэрлэсэн | Хуулийн хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн | Иргэний талд шийдвэрлэсэн | Хууль, тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх боломжгүй | Тодорхой бус хариу өгсөн | Харьяаллын дагуу шийдэх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлсэн тоо | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн тоо | Хуулийн хугацаа болоогүй | Шийдвэр лээгүй |
| А | Б | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар | 1 | 113 | 72 | 30 | 93 | 9 | - | 18 | - | 4 | 6 |
| **Дүн** | | **113** | **72** | **30** | **93** | **9** | **-** | **18** | **-** | **4** | **6** |

Тайлбар: Нэг өргөдөл гомдолд хариу өгөх шаардлагагүй байсан тул танилцаж хаасан.

Мэдээ гаргасан: Хүний нөөцийн мэргэжилтэн Н.Дагиймаа ..................................

/Албан тушаал/ /Нэр/ /Гарын үсэг/

2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр